



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2017-11-17 № 4-1/6543

танай _____-ны № _____-т

**Монгол Улсын 2018 оны төсөв
хүргүүлэх тухай**

Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулийн төслүүд Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр сарын 14-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар батлагдлаа.

Монгол Улсын Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлого 7,231.4 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 23.8 хувь, тэнцвэржүүлсэн орлогод нийцүүлсэн нэгдсэн төсвийн нийт зарлага 9,651.5 тэрбум төгрөг буюу ДНБ-ий 31.8 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцэл 2,420.1 тэрбум төгрөгийн алдагдалтай буюу ДНБ-ий -8.0 хувьтай байхаар тус тус төлөвлөө.

Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, төсвийн сар, улирлын хуваарийг боловсруулах ажлын хүрээнд тухайн төсвийн жилийн онцлог, анхаарах зүйлс, төсвийн хуваарийг боловсруулах удирдамжийг үүгээр хүргүүлж байна.

Монгол Улсын 2018 оны төсвийн сар, улирлын хуваарийг дараах зарчмыг баримтлан боловсруулна. Үүнд:

1. Төсвийн орлогыг төвлөрүүлэгч байгууллагуудын хувьд төсөвт төвлөрүүлэх орлогын хуваарийг боловсруулахдаа Сангийн яамнаас боловсруулсан 2018 оны макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд болон тухайн орлогод нөлөөлөгч гол хүчин зүйлийн талаарх төсөөлөлтэй уялдуулж, тухайн орлогын улирлын шинж чанарын нөлөөллийг тусган тооцох;
2. Төсвийн орлого төвлөрүүлэх хуваарийг боловсруулахдаа өмнөх жилүүдийн гүйцэтгэл, орлогын төлөвлөгөөний биелэлтэд үндэслэн төлөвлөх;
3. Аливаа арга хэмжээний зардлын хуваарийг боловсруулахдаа байгууллагын үйл ажиллагаа, төлөвлөгөөтэй уялдуулан хэвийн явуулах зорилгоор оны эхнээс оновчтой жигд хуваарилах;
4. Батлагдсан төсвийн орлого, зарлагын сар, улирлын хуваарилалтыг хийхдээ жилийн төлөвлөгөөтэй тэнцүү байхаар боловсруулах;
5. Өр, төлбөр үүсгэхгүй байх нөхцөлийг хангах;
6. Түлш халаалтын зардлыг хуваарилахдаа тухайн орон нутгийн онцлог, халаалтын улирал болон түлш бэлтгэх хугацааг харгалзах;
7. Төсөвт байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогоор санхүүжих зардлын хуваарийг тухайн орлогын хуваарьтай уялдуулах;
8. Шинээр батлагдсан хууль, эрх зүйн актыг хэрэгжүүлэхэд анхаарах;

9. Төсвийн орлого, зарлагын уялдааг хангаж, их хэмжээний хөрөнгө шаардсан хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг орлогын биелэлттэй уялдуулан хэрэгжүүлэхээр зохицуулах;

Дээр дурдсан шаардлагуудыг анхааралдаа авч, төсвийн зарлага, санхүүжилт болон орлогын хуваарийн саналыг холбогдох үндэслэлийн хамт 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Заасан хугацаанаас хожимдуулсан тохиолдолд саналыг хүлээн авахгүй болохыг мэдэгдье.

Монгол Улсын 2018 оны төсвийн мэдээлэл, хуулиудын эхийг Төсвийн ил тод байдлын www.iltod.gov.mn болон Сангийн яамны www.mof.gov.mn вэб хуудсанд, мөн Төрийн сангийн сүлжээ дээр байршуулсан болно.

Хавсралт №1. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын 2018 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх чиглэл;

Хавсралт №2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн орлого;

Хавсралт №3. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны төсвийн зарлага;

Хавсралт №4. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт;

Хавсралт №5. Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2018 онд санхүүжүүлэх "Барих-Шилжүүлэх" концессын төрлөөр хэрэгжүүлсэн

Хавсралт №6. Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсөв;

Хавсралт №7. Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсөв;

Хүндэтгэсэн,



Ч.ХҮРЭЛБААТАР